



Аудитын код: САГ-2017/07/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261740 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Х.Оюунчимэг

Утас: 261885 Цахим хаяг: oyunchimegkh@audit.gov.mn

Улаанбаатар хот

Агуулга

Аудитын гэрчилгээ	2
1 Аудитын тайлан	4
1.1 Оршил	4
1.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	4
1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
1.5 Дотоод хяналт	7
1.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	7
1.7 Шилэн дансны мэдээлэл	7
1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	8
1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	8
1.9.1 Санхүүгийн тайлагналын талаар	8
1.9.2 Мөнгөн хөрөнгийн талаар	8
1.9.3 Үндсэн хөрөнгийн талаар	9
1.9.4 Зардлын бүртгэлийн талаар	9
1.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
1.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	11
1.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	11
1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
1.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	12
1.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	12
2 Менежментийн захидал	13
2.1 Мөнгөн хөрөнгийн талаар	14
2.2 Үндсэн хөрөнгийн талаар	15
2.3 Зардлын бүртгэлийн талаар	16
3 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	18
3.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	18
3.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	19
3.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	21
3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22

Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.04.25 № 759

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Ж.МӨНХБАТ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Мөнхбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

1.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 17-ноос 2017 оны 4 дүгээр сарын 21-ний хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Х.Оюунчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн ХЭГ/543 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

1.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Монгол Улсын Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн, Төрийн болон орон нутгийн өмчийн, Татварын ерөнхий хуулиуд болон холбогдох тогтоол, шийдвэр, журам, зааврын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын эрхэм зорилго нь мэргэшлийн өндөр түвшний, цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр Ерөнхий сайд, Танхимыг шуурхай хангах, Засгийн газрын тасралтгүй, хэвийн, үр ашигтай ажиллагааны зохистой орчин бүрдүүлэхэд оршино.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

- Засгийн газрын бодлого, шийдвэрийг боловсруулах, хуралдаанд бэлтгэх болон яам, Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ чиглэлээр цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Хууль тогтоомжийн болон Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах, хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлыг зохицуулах, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж, агуулгыг найруулах, энэ чиглэлээр удирдлагыг арга зүй, мэдээлэл, үйлчилгээгээр хангах;
- Ерөнхий сайд, Танхим, бүх шатны Хурал, Засаг даргыг орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, нутгийн удирдлагын чиглэлээр өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэгээр шуурхай хангах, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааны үр нөлөөтэй, хэвийн жигд ажиллагааны эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх;
- Танхимын хуралдааны зохион байгуулалт, хүний нөөцийн болон захиргааны удирдлагын манлайллыг хангах, төсвийн ерөнхийлөн захирагч болон шууд захирагчид санхүүгийн үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих хяналт, шалгалт, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үр дүнд өгөх үнэлгээний үр ашгийг дээшлүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчийн хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, ТАБ-СТА-А-1 маягтад тусгасан.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 1.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 дансанд түүвэрчилсэн байдлаар аудитын 11 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 1.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2015 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас 2016 онд авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэхгүй байна. Гэвч дараах асуудлыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дэлгэрэнгүй тусгах нь зүйтэй. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;
- Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй

байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

1.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2016 оны 39 дүгээр тушаалаар дотоод аудитын дүрмийг баталж, 2 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Дотоод аудитын алба нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, санхүүгийн тайлан, салбарын нэгжүүдийн үйл ажиллагаанд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж, эрсдэлийн удирдлагаар хангах ажлыг эрхлэн гүйцэтгэж байна.

Дотоод аудитын алба 2016 онд Удирдлагын академи, Засгийн газрын хэвлэх үйлдвэр ТӨААТҮГ-ын 2015, 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийжээ.

1.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2016 оны жилийн төсөв 19,483.8 сая төгрөгөөр батлагдаж 15,246.6 сая төгрөгийн буюу 78.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

2016 оны төсвийн зардлын гүйцэтгэл хэмнэлттэй гарсан нь төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний хүрээнд санхүүжилт бүрэн хийгдээгүйгээс шалтгаалсан байна. Хэмнэгдэж байгаа зардлын 34.3 хувь буюу 1,457.0 сая төгрөг нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, 2.5 хувь буюу 105.0 сая төгрөг нь Ерөнхий сайдын ажлын албаны төсвийн хэмнэлт байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор, Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газар, Удирдлагын академи, Байр ашиглалтын нэгдсэн захиргаа, Засгийн газрын хэвлэх үйлдвэр, төсөл сангуудын зарим гүйлгээг мөнгөн гүйлгээний тайланд төсвийн тохируулга хийж цэвэрлэж тайлагнасан байна

1.7 Шилэн дансны мэдээлэл

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д заасны дагуу холбогдох мэдээ, мэдээллийг хуульд заасан хугацаанд шилэн дансны нэгдсэн веб хуудас болох www.shilendans.gov.mn болон байгууллагын www.cabinet.gov.mn веб хуудсуудаар бүрэн мэдээлсэн байна.

Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хувьд нэгдсэн веб хуудас www.shilendans.gov.mn-ийг хөтлөн Шилэн дансны хуулийн дагуу мэдээ мэдээллийг бүрэн олон нийтэд тайлагнан ажиллаж, харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг улирал бүр нэгтгэн холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан байна.

/сая төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт гүйлгээ	Орлогын гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Зарлагын гүйлгээний тоо	Мөнгөн дүн	Нийт дүн
1	ЗГХЭГ	100	38	6,295.7	62	2,919.2	9,214.9
2	МУ-ын Ерөнхий сайдын ажлын алба	11	11	989.9			989.9
3	Шадар сайдын ажлын алба	12	12	165.1			165.1

1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 11 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 1.9-д хураангуйлан тэмдэглэв.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

1.9.1 Санхүүгийн тайлагналын талаар

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нэгтгэсэн санхүүгийн тайланд 66.0 сая төгрөгийн авлага дутуу тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийлгэв.

1.9.2 Мөнгөн хөрөнгийн талаар

Төсвийн байгууллагын касс т их хэмжээний бэлэн мөнгөний үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмын 6.2-д "Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ (ЖМС) нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс (ЖБТ) хамааран дараах хэмжээтэй байна. ЖБТ 1,000,000,000 төгрөгөөс дээш -ЖМС 1,500,000- 3,000 000 төгрөг" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.

1.9.3 Үндсэн хөрөнгийн талаар

Үндсэн хөрөнгийн элэгдэлийг нэг төрлийн хөрөнгөнд харилцан адилгүй жилээр тооцсон нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.29-д Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-г дагаж мөрдөнө" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох жил, хувийг тусган, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар батлуулан салбарын хэмжээнд мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

1.9.4 Зардлын бүртгэлийн талаар

ЗГХЭГ-ын даргын төсвөөс Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны төсөвт 18.8 сая төгрөгийн цалингийн зардал, ХХОАТ-ын өглөгийн төлбөрийг гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 42.2-д "Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно:", 42.2.1.г-д "түүнд шууд харьяалагдах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд" 42.4-д "Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна." заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 16.2 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.", 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" заалтуудыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэлтэнд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгсөн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь 27.0 сая төгрөгийн тэмдэглэлт ойн арга хэмжээний зардалд харьцуулалтын аргыг хэрэглээгүй шууд гэрээ байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно." гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Хууль, журмыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

Тайлант онд бэлэг дурсгалын зүйлсийг худалдан авахдаа худалдан авах ажиллагааны журмыг хэрэгжүүлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4."Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно." заалтыг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Хууль, журмыг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын талаарх тайлбар:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд Монгол Улсын Ерөнхий сайдын ажлын алба, Шадар сайдын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн түүхийн музей, Удирдлагын академи /УТҮГазар/, Төр засгийн үйлчилгээ эрхлэх газар /УТҮГ/, Засгийн газрын байр ашиглалтын нэгдсэн захиргаа /УТҮГ/, Засгийн газрын авто бааз /УТҮГазар/, Засгийн газрын хэвлэх үйлдвэр /УҮГ/, Төр засгийн Амралт үйлчилгээний цогцолбор /УҮГ/, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хөрөнгө оруулалт их засвар, Хөрөнгө оруулалтын барьцаа, Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага төсөл", "Ухаалаг засаглал төсөл", ЗГХЭГ-ын ахмадын сан, Бүс нутгийн хилийн боомтуудын үйл ажиллагааг сайжруулах төсөл, Засаглалыг дэмжих төвлөрлийг сааруулах хөтөлбөр зэрэг нийт 17 байгууллага нэгж нэгтгэгдсэн байна. **Үүнээс:** Аудитын түүвэрт 6, Хараат бус аудитын компани 7, нийт 13 байгууллага аудитад хамрагдсан байна.

Дэлхийн банкнаас хэрэгжиж байгаа 4 төсөл аудитад хамрагдаагүй байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нэгтгэсэн тайланд нийт 17 байгууллага аудитад хамрагдахаас 6 байгууллагад Үндэсний аудитын газар, 7 байгууллагыг Хараат бус аудитын компаниар аудит хийлгэж, бусад 4 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Хараат бус аудитын компанийн гэрээгээр гүйцэтгэсэн 7 байгууллага нь **"Зөрчилгүй"** санал дүгнэлт авсан байна. Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Төр засгийн амралт үйлчилгээний цогцолбор:

- Санхүүгийн тайланд 3.4 сая төгрөгийн НДШ-ийн өр төлбөрийн үлдэгдэлийг дутуу тусгасан;
- Бараа материалын дансаар дамжуулалгүй 9.8 сая төгрөгийг зардалд шууд тусгасан;

Засгийн газрын авто бааз:

- Батлагдсан төсөвт тусгагдаагүй Lexus-570 автомашиныг 195.5 сая төгрөгөөр худалдан авсан;
- Тайлант онд авлага үүсгэсэн;

Засгийн газрын нэгдсэн байруудын захиргаа:

- Тайлант онд 102.9 сая төгрөгийн элэгдлийн зардлыг илүү тайлагнасан;
- Хөрөнгийн тооллогын комисс нь үндсэн хөрөнгийн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг холбогдох заавар журмын дагуу бүрэн хийгээгүй;

Төр засгийн үйлчилгээг эрхлэх газар:

- 71.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэн зөв ангилж бүртгээгүй;

Төрийн түүхийн музей:

- Тайлант онд 6.1 сая төгрөгийн авлага үүсгэсэн;

1.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Бэлэг дурсгалын зүйлс зарцуулахдаа 1999 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Бэлэг, дурсгалын зүйл гардуулах, хүлээн авах, тайлагнах, зарцуулах” журмыг мөрдөж ажиллахад одоогийн зах зээлийн үнэтэй нийцэхгүй байна. Үүнийг цаашид анхаарах шаардлагатай.

Аудитын явцад Сангийн яамны Төрийн сангийн газраас ирүүлсэн ТЕЗ болон Сангийн яам хооронд тооцоо нийлсэн баримт нь зөвхөн урсгал санхүүжилтийн гүйлгээг агуулсан байна. Мөн Төв төрийн сангийн төсвийн хэлбэлзлийн тайлан эцэслэгдээгүй, нэгтгэлийн Э-тайлан програмаас хэвлэгдэж буй санхүүгийн байдлын тайланд Засгийн газрын хувь оролцооны дүн дутуу татагдаж байгаа нь ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг ЗГСНТ-д нэгтгүүлэхэд зарим тоон мэдээлэл өөрчлөгдөх эрсдэл үүсэх магадлалтай байна.

1.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит хийж буй цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан хөрөнгөнд биет тест хэрэгжүүлээгүй болно.

Энэ нь аудитын хамрах хүрээний асуудал боловч цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан аудитын явцад гүйцээж мөшгин, шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох дээрх асуудлыг 2017 оны завсрын аудитаар нөхөн шалгах болно.

Удирдлагын академи нь төрийн албан хаагчдыг сургахад төсвөөс санхүүжилт авч суралцагчдыг сургаж байгаа боловч сонсогч, суралцагч бүрээр суралцсан хугацаа, судалсан кредитэд үндэслэн бодитой тооцоогүйд анхаарах хэрэгтэй байна.

1.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 517.0

сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 172.3 сая төгрөгийн алдааг залруулж, 18.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 325.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг өгсөн.

1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 4 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх зөвлөмжид Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох жил, хувийг тусган, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар батлуулан салбарын хэмжээнд мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгсөн бөгөөд 2016 онд энэ зөрчил дахин гаргасанд анхаарал хандуулж, тодорхой арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй.

1.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 31,566.3 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 631.3 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

1.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 1.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

2.1 МӨНГӨН ХӨРӨНГИЙН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
<u>ҮАГ-ын ажиглалт</u> Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдах зарим байгууллагуудын мөнгөн хөрөнгийн дансанд аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад бэлэн мөнгөний кассанд их хэмжээний мөнгөний үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журмын 6.2-д "Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс хамааран дараах хэмжээтэй байна. ЖБТ 1,000,000,000 төгрөгөөс дээш -ЖМС 1,500,000- 3,000 000 төгрөг" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна. <u>Эрсдэлүүд</u> Санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байхгүй байх;	<u>ҮАГ-ын зөвлөмж</u> Мөнгөн кассын ажиллагааны журмын 6.2 дахь заалтыг мөрдөж ажиллах; Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх. <u>Төсвийн захирагчийн хариу</u> Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

2.2 Үндсэн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Үндсэн хөрөнгийн элэгдэлийн тооцооллыг давтан шалгаж үзэхэд нэг төрлийн хөрөнгөнд харилцан адилгүй жилээр тооцсон нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.29-д Үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, тэдгээрийн дансны үнэ, элэгдэл шимтгэлийн хэмжээг тодорхойлох, дахин үнэлгээ зэрэг нягтлан бодох бүртгэлийг УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө"-г дагаж мөрдөнө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.29-д заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтээ үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох жил, хувийг тусган, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар батлуулан салбарын хэмжээнд мөрдөж ажиллах;

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэхгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

2.3 ЗАРДЛЫН БҮРТГЭЛИЙН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

ЗГХЭГ-ын даргын төсвөөс Монгол Улсын Шадар сайдын ажлын албаны төсөвт 18.8 сая төгрөгийн цалингийн зардал, ХХОАТ-ын өглөгийн төлбөрийг гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 42.2-д “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно:”, 42.2.1.г-д “түүнд шууд харьяалагдах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд” 42.4-д “Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна.” заалтыг зөрчсөн байна.

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар 16.2 сая төгрөгийн гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно.", 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь тэмдэглэлт ойн арга хэмжээтэй холбогдон гаргасан 27.0 сая төгрөгийн зардалд харьцуулалтын аргыг хэрэглээгүй шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно.” гэсэн заалтыг зөрчсөн.

Тайлант онд бэлэг дурсгалын зүйлсийг худалдан авахдаа худалдан авах ажиллагааны журмыг хэрэгжүүлээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.4-д "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно." гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 41.2.2-д заасны дагуу батлагдсан төсвийн хүрээнд зарцуулах;

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 20.1.4-д заасны дагуу анхан шатны баримтын бүрдэлтэнд тавих хяналтыг сайжруулах;

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа аргыг зөв сонгох;

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны
төсвийн захирагчийн зөвшөөрлийг аваагүй байх

Холбогдох хууль, заавар журам хэрэгжихгүй байх;

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч
хэрэгжүүлнэ.

3 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

3.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян. төг/			
Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		9,759,558.8	10,932,530.1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	5,752,429.5	6,744,730.4
АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	1,575,546.5	1,566,447.1
УРЬДЧИЛГАА	7а, 7б	99,858.1	256,435.3
БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	2,331,724.7	2,364,917.2
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		53,845,197.3	50,972,864.0
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	53,845,197.3	50,972,864.0
Биет хөрөнгө		53,271,626.1	50,923,193.5
Биет бус хөрөнгө	13	573,571.2	49,670.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		63,604,756.1	61,905,394.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР		3,018,980.9	2,026,356.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	3,018,980.9	2,026,356.4
Өглөг	17а, 17б	362,568.2	262,051.2
Урьдчилж орсон орлого	18а, 18б	2,656,412.7	1,764,305.2
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		60,585,775.2	59,879,037.7
Засгийн газрын хувь оролцоо		60,585,775.2	59,879,037.7
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		34,866,306.5	34,952,824.8
Хуримтлагдсан үр дүн		6,849,605.4	5,973,248.5
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		18,869,863.3	18,952,964.4
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		63,604,756.1	61,905,394.1

3.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян төг/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		32,586,881.4	30,579,902.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	17,714,099.6	14,513,441.7
Нийтлэг татварын бус орлого		17,159,884.0	13,707,885.3
Хөрөнгийн орлого		0.0	248,275.0
Тусламжийн орлого		554,215.5	557,281.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		14,872,781.9	16,066,460.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	28,213,430.8	31,566,301.4
УРСГАЛ ЗАРДАЛ		25,325,513.1	28,646,604.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		23,893,081.3	26,686,850.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		9,315,625.7	9,728,218.7
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,156,018.9	1,063,580.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,737,252.0	2,007,177.0
Хангамж, бараа материалын зардал		2,989,646.8	2,745,435.7
Нормативт зардал		27,151.2	27,124.8
Эд хогшил, урсгал засварын зардал		708,988.3	1,425,103.2
Томилолт, зочны зардал		1,384,729.0	846,543.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,233,062.0	3,371,078.8
Бараа үйлчилгээний бусад зардал		5,340,607.4	5,472,587.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,432,431.8	1,959,754.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		2,887,917.8	2,919,696.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		4,373,450.6	-986,399.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		26,429.5	405,027.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		54,480,033.1	294,985.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-50,080,153.0	-876,356.9

3.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	111,368,866.4	111,368,866.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	54,406,566.6	54,406,566.6
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	165,775,433.0	165,775,433.0
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-599.7	-599.7
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-55,108,905.0	-55,108,905.0
Тайлант үеийн үр дүн	-50,080,153.0	-50,080,153.0
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	60,585,775.2	60,585,775.2
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	60,585,775.2	60,585,775.2
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	60,585,775.2	60,585,775.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	83,101.1	83,101.1
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	86,518.3	86,518.3
Тайлант үеийн үр дүн	-876,356.9	-876,356.9
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,879,037.7	59,879,037.7

3.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мян төг/

Тайлангийн үзүүлэлт	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	32,584,075.2	29,503,055.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,709,135.7	12,932,593.5
Нийтлэг татварын бус орлого	17,154,920.1	12,375,312.2
Тусламжийн орлого	554,215.5	557,281.3
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	14,874,939.6	16,570,461.6
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	23,248,295.6	24,833,595.1
УРСГАЛ ЗАРДАЛ	23,248,295.6	24,833,595.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,716,596.5	22,966,935.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,381,835.1	9,713,352.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,435,924.2	1,139,785.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,721,338.5	2,011,585.6
Хангамж, бараа материалын зардал	3,231,770.5	2,581,074.1
Нормативт зардал	31,851.1	91,209.2
Эд хогшил, урсгал засварын зардал	785,165.3	1,347,092.4
Томилолт, зочны зардал	1,352,681.5	892,609.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,457,236.6	2,472,129.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,318,793.7	2,718,097.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,531,699.0	1,866,659.6
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	9,335,779.7	4,669,460.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,291,015.9	4,081,914.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,291,015.9	4,081,914.3
Дотоод эх үүсвэрээр	4,291,015.9	4,081,914.3
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,291,015.9	-4,081,914.3
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	6,753.0	404,755.3
Бусад эх үүсвэр	0.0	404,755.3
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-6,753.0	0.0
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	5,051,516.8	992,301.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	700,912.7	5,752,429.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,752,429.5	6,744,730.4

3.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ мян төг/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,483,763.3	15,246,558.0	4,237,205.3	78.3
УРСГАЛ ЗАРДАЛ	16,057,147.3	12,372,797.6	3,684,349.7	77.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,233,233.4	11,604,334.8	3,628,898.6	76.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,507,964.2	5,392,313.5	115,650.7	97.9
Үндсэн цалин	4,296,602.0	4,139,106.8	157,495.2	96.3
Нэмэгдэл	35,102.4	34,590.5	511.9	98.5
Унаа хоолны хөнгөлөлт	475,070.4	517,426.8	-42,356.4	108.9
Гэрээт ажлын хөлс	701,189.4	701,189.4	0.0	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	642,160.6	607,641.8	34,518.8	94.6
Тэтгэврийн даатгал	384,086.9	376,256.7	7,830.2	98.0
Тэтгэмжийн даатгал	44,031.7	42,946.4	1,085.3	97.5
ҮОМШӨ-ний даатгал	71,375.0	69,537.2	1,837.8	97.4
Ажилгүйдлийн даатгал	11,007.9	10,669.3	338.6	96.9
Эрүүл мэндийн даатгал	131,659.1	108,232.0	23,427.1	82.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,011,557.7	979,003.7	32,554.0	96.8
Гэрэл, цахилгаан	346,910.3	403,433.8	-56,523.5	116.3
Түлш, халаалт	475,647.4	396,518.0	79,129.4	83.4
Цэвэр, бохир ус	189,000.0	179,051.9	9,948.1	94.7
Хангамж, бараа материалын зардал	540,881.0	531,457.8	9,423.2	98.3
Бичиг хэрэг	69,704.6	60,035.1	9,669.5	86.1
Тээвэр, шатахуун	300,499.8	302,079.6	-1,579.8	100.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	80,429.5	74,289.6	6,139.9	92.4
Ном, хэвлэл	0.0	5,592.4	-5,592.4	
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,966.4	3,074.3	892.1	77.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	86,280.7	86,386.8	-106.1	100.1
Нормативт зардал	16,238.0	15,771.8	466.2	97.1
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,000.0	942.5	57.5	94.3
Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,238.0	14,829.3	408.7	97.3
Эд хогшил, урсгал засварын зардал	112,304.7	109,273.6	3,031.1	97.3
Багаж, техник, хэрэгсэл	8,015.7	17,204.1	-9,188.4	214.6
Тавилга	11,877.9	9,490.0	2,387.9	79.9
Урсгал засвар	92,411.1	82,579.4	9,831.7	89.4
Томилолт, зочны зардал	842,320.1	747,470.2	94,849.9	88.7
Гадаад албан томилолт	245,595.9	289,917.6	-44,321.7	118.1
Дотоод албан томилолт	292,238.0	146,351.9	145,886.1	50.1
Зочин төлөөлөгч хүлээн авах	304,486.2	311,200.8	-6,714.6	102.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,853,683.2	2,243,721.1	1,609,962.1	58.2
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,395,095.4	2,015,372.0	1,379,723.4	59.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000.0	0.0	1,000.0	
Даатгалын үйлчилгээ	12,000.0	12,000.0	0.0	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	183.8	0.0	183.8	
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	440,274.0	214,266.5	226,007.5	48.7
Газрын төлбөр	5,130.0	2,082.5	3,047.5	40.6
Бараа үйлчилгээний бусад зардал	2,706,123.9	977,681.4	1,728,442.5	36.1

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Бараа үйлчилгээний бусад зардал	2,706,123.9	977,681.4	1,728,442.5	36.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	823,913.9	768,462.8	55,451.1	93.3
Засгийн газрын урсгал шилжүүлэг	625.0	0.0	625.0	
Засгийн газрын гадаад шилжүүлэг	625.0	0.0	625.0	
Бусад урсгал шилжүүлэг	823,288.9	768,462.8	54,826.1	93.3
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	624,303.0	574,647.1	49,655.9	92.1
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,000.0	33,440.0	2,560.0	92.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	162,985.9	160,375.6	2,610.3	98.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,426,616.0	2,873,760.5	552,855.6	83.9
Барилга байгууламж	1,861,616.0	1,812,067.5	49,548.5	97.3
Тоног төхөөрөмж	1,565,000.0	1,061,693.0	503,307.0	67.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,483,763.3	15,026,498.7	4,457,264.6	77.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	15,004,896.3	13,038,128.3	1,966,768.0	86.9
Улсын төсвөөс санхүүжих	15,004,896.3	13,038,128.3	1,966,768.0	86.9
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,442,994.7	1,519,203.1	1,923,791.6	44.1
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	142,500.0	231,725.1	-89,225.1	162.6
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,300,494.7	1,287,478.1	2,013,016.6	39.0
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	1,035,872.3	469,167.2	566,705.1	45.3
Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	1,035,872.3	469,167.2	566,705.1	45.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	2,322,040.5	2,322,040.5	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	2,039,927.5	2,039,927.5	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,139	1,131	8	99.3
БАЙГУУЛЛАГЫН ТОО	7	7		100.0
Төсвийн байгууллага	7	7		100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	566	562	4	99.3
Удирдах ажилтан	24	24		100.0
Гүйцэтгэх ажилтан	351	351		100.0
Үйлчлэх ажилтан	85	81	4	95.3
Гэрээт ажилтан	106	106		100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	566	562	4	99.3
Ажлын албаны албан хаагч (АА)	94	94		100.0
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	16	12	4	75.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	430	430		100.0
Улс төрийн албан хаагч (УТ)	26	26		100.0